

**Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит
сонгуульд бие даан нэр дэвшигч Ц.Баттулгыч мөрийн хөтөлбөр**

1. “Эрүүл иргэн –Эко бүтээгдэхүүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар эм болон хоол хүнсний зохистой хэрэглээг төлөвшүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх эрүүлжүүлэх зорилгоор мэдээлэл сургалт сурталчилгааг төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ.
2. Цөлжилтийг сааруулах, элсний нүүдлийг багасгах зорилгоор говийн нөхцөлд ургадаг мод бутлаг ургамлыг тарималжуулсан, байгууллага иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоо, төрийн бус байгууллагыг дэмжих урамшууллын системийг орон нутагтай хамтран бий болгоно.
3. Хүүхдийн хөгжил, хүүхэд хамгааллыг дэмжиж тэднийг хөгжилд хөтлөхүйц тоглоом наадгай бүхий тоглоомын танхим байгуулах, хүүхэд бүрийн авьяасыг нээн илрүүлэх хөгжүүлэх зорилгоор орон нутгийн болон бүсийн тэмцээн уралдаан зохион байгуулна.
4. Жижиг дунд үйлдвэрлэл бизнесийг хөгжүүлэх чиглэлээрх шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж аялал жуулчлалын бодлогыг орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаатай холбон орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.
5. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга бат, ажлын үр дүнг сайжруулах мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин бүхий төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх үүднээс төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд иргэдийн санал асуулгын дүнг гол үзүүлэлт болгоход анхаарч ажиллана
6. Орон нутгийн хөгжлийн бодлогыг иргэдийн оролцоо хамтын ажиллагааны зарчмаар тодорхойлж иргэдийн ажиллаж амьдрах, эрүүл тохилог, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор “Орон нутгийн хөгжлийн сан”-г иргэд олон нийтийн оролцоотойгоор төлөвлөж, зарцуулалтад тавих иргэдийн хяналтыг бий болгоно.
7. Иргэний нээлттэй танхимаар дамжуулан бүх төрлийн мэдээ мэдээллийг нийт иргэдэд хүргэх, түгээх, олон нийтийн оролцооны нээлттэй хэлэлцүүлэг хийдэг үйл ажиллагааг хэвшүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах, хянах, хариуцлага тооцох бололцоог бүрдүүлнэ.
8. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн үйлдвэрлэлийг байгаль орчинд хор хөнөөлгүйгээр явуулж байгаа болон ашиглалтын явцад байнгын хяналт тавих ажлын хэсэгт иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ
9. Соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, өвлөн уламжлуулах, дэмжих талаар орон нутгийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан:  **Ц.Баттулга**

